

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халхгол сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2024/10/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)  
Аудитын менежер: И.Сэмжидмаа  
Утас: 7058-4204, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Д.Нармандах  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakh@audit.gov.mn](mailto:narmandakh@audit.gov.mn)  
Аудитор: Г.Ганбилэг  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [ganbilegg@audit.gov.mn](mailto:ganbilegg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4-8
3. Аудитын илрүүлэлт .....	9
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	10

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.25 № 318

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Халхгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөх аудитаар илэрсэн асуудал давтан гарч байна.

#### Аудитын гол асуудал

Дорнод аймгийн Халхгол сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар тогтоолоор 92.2 хувиар дүгнэсэн байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011021192

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	764,044.4	1,998,421.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	223,239.5	1,337,833.6
33	АВЛАГА	261,263.4	213,243.0
35	БАРАА МАТЕРИАЛ	279,541.4	447,344.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	17,385,054.7	16,350,218.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,385,054.7	16,350,218.3
39200	Биет хөрөнгө	17,375,964.4	15,959,772.4
39300	Биет бус хөрөнгө	9,090.3	390,445.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	18,149,099.0	18,348,639.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,870.0	101,106.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,870.0	101,106.6
41300	Өглөг	25,870.0	101,106.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	18,123,229.0	18,247,533.0
51	Засгийн газрын хувь оролцоо	18,123,229.0	18,247,533.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,458,571.5	1,840,833.5
51200	Хуримтлагдсан үр дүн	15,989,343.2	15,731,385.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	675,314.3	675,314.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	18,149,099.0	18,348,639.6

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,902,435.2	7,342,528.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,224,903.3	2,940,308.7
110	Орлогын албан татвар	1,075,034.6	1,542,201.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,085,022.4	1,552,114.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,987.8	-9,912.5
113	Хөрөнгийн албан татвар	44,052.0	73,111.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105,816.7	1,324,995.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,563,941.1	2,635,363.2
120	Нийтлэг татварын бус орлого	4,353,941.1	1,907,992.7
122	Тусламжийн орлого	210,000.0	727,370.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,113,590.8	1,766,856.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,754,242.2	3,701,645.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,754,242.2	3,701,645.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,801,571.5	3,462,435.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	428,124.2	454,544.8

Халхгол сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,562.6	56,349.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	287,687.1	39,113.9
2104	Хангамж, бараа материалын зардал	84,738.4	81,481.5
2105	Нормативт зардал	279.5	600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,809.3	12,423.1
2107	Томилолт, зочны зардал	14,471.8	18,255.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	497,036.2	1,107,553.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,410,862.4	1,692,113.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,952,670.7	239,210.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,148,193.0	3,640,883.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	19,900,672.6	3,915,876.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-15,752,479.6	-274,992.8

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,037,683.3	0.0	34,037,683.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-161,974.7	0.0	-161,974.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,875,708.6	0.0	33,875,708.6
9	Тайлант үеийн үр дүн	-15,752,479.6	0.0	-15,752,479.6
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,123,229.0	0.0	18,123,229.0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	18,123,229.0	0.0	18,123,229.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	17,034.8	0.0	17,034.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,140,263.8	0.0	18,140,263.8
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	382,262.0	0.0	382,262.0
19	Тайлант үеийн үр дүн	-274,992.8	0.0	-274,992.8
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	18,247,533.0	0.0	18,247,533.0

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,172,374.2	6,229,974.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,224,903.3	2,940,308.7
110	Орлогын албан татвар	1,075,034.6	1,542,201.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,085,022.4	1,552,114.3

Халхгол сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,987.8	-9,912.5
113	Хөрөнгийн албан татвар	44,052.0	73,111.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105,816.7	1,324,995.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,955.2	1,893.5
1181	Газрын төлбөр	98,234.8	1,323,073.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,626.7	28.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	833,880.1	1,522,809.4
120	Нийтлэг татварын бус орлого	623,880.1	795,438.9
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	210,000.0	727,370.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,113,590.8	1,766,856.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,472,959.2	2,479,133.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,472,959.2	2,479,133.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,520,288.5	2,239,923.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,133.2	628,935.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,901.8	105,495.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	363,131.1	135,184.2
2104	Хангамж, бараа материалын зардал	314,254.4	460,750.9
2105	Нормативт зардал	1,974.6	600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,611.8	13,542.1
2107	Томилолт, зочны зардал	14,471.8	18,255.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,995.5	458,840.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,814.3	418,319.5
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,952,670.7	239,210.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,699,415.0	3,750,841.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,728,567.4	2,636,247.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,728,567.4	2,636,247.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1,728,567.4	2,636,247.0
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,728,567.4	-2,636,247.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-120,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-149,152.4	1,114,594.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	372,391.9	223,239.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	223,239.5	1,337,833.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4,391,028.50	4,162,658.40
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,631,165.80	1,548,059.40
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,391,955.50	1,308,849.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,125.80	454,544.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ши	63,071.50	56,349.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	481,103.20	454,157.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,195.50	36,195.50
2105	Нормативт зардал	600.00	600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,042.10	20,042.10
2107	Томилолт, зочны зардал	10,943.80	10,191.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тө	18,714.30	16,408.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	269,159.30	260,360.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	239,210.30	239,210.30
2131	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад	220,367.70	220,367.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,842.60	18,842.60
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,759,862.70</b>	<b>2,614,599.00</b>
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,391,028.50	4,197,748.80
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,528,941.00	3,336,817.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	136,087.50	133,561.40
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	726,000.00	727,370.50
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэ	-	59,952.20
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгд	-	95,042.70

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>287,076.50</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>271,078.50</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>219,321.40</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	44,148.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,064.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,959.50
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51,757.10</b>
2131	Олгосон санхүүжилт шилжүүлэг	51,757.10
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,998.00</b>

Халхгол сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2200	Дотоод эх үүсвэрээр	15,998.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>287,076.50</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>287,076.50</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	245,203.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,873.0

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 329.3 сая төгрөгийн 5 зөрчил<sup>1</sup> илэрснээс 329.3 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Албан шаардлага

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн 117.6 сая төгрөгийн "Гүний худаг цэвэршүүлэх" төсөл огт хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", 29.4-д "Хөрөнгө оруулалтын төсөвт... хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Малын тоо толгойн албан татвар 30.5 сая төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 58.0 сая төгрөгөөр, газрын төлбөр 66.8 сая төгрөгөөр тасарч, хог хаягдлын үйлчилгээний төлбөрийн орлого 8.4 сая төгрөг төлөвлөсөн боловч биелээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон ... орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

3. ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн 48.0 сая төгрөгийн 2 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

4. Өмнө оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 168/03 ДОА-2023/101 НА-СТА-ТТЗ А1170311 дугаартай 385.5 сая төгрөгийн албан шаардлага биелээгүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасан байна.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Халхгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн дансны цахим хуудсанд тухай бүр мэдээлэх 12 мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалттай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн утга	Нийт зөрчил/сая.төг/		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд тухай бүр мэдээлэх 12 мэдээлийг мэдээлээгүй байна.	1	-					1	-				
Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн 117.6 сая төгрөгийн "Гүний худаг цэвэршүүлэх" төсөл огт хэрэгжээгүй байна	1	117.6			1	117.6						
Сумын орлого тасарсан байна.	1	163.7			1	163.7						
ОНХС-ийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн 48.0 сая төгрөгийн 2 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна	1	48.0			1	48.0						
Өмнө оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 385.5 сая төгрөгийн албан шаардлага биелээгүй байна	1	-			1	-						
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>329.3</b>			<b>4</b>	<b>329.3</b>	<b>1</b>	<b>-</b>				



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар 01/111 ДОА-2024/10/НА-СТА-ТТЗ А-1171130 Чойбалсан хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Халхгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

Халхгол сумын засаг дарга Х.Хүрэл-Эрдэнэд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл тооцож, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



011041336



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 02/112 ДОА-2024/10/НА-СТА-ТТ3  
А1191130

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын тоо толгойн албан татвар 30.5 сая төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 58.0 сая төгрөгөөр, газрын төлбөр 66.8 сая төгрөгөөр тасарч, хог хаягдлын үйлчилгээний төлбөрийн орлого 8.4 сая төгрөг төлөвлөсөн боловч биелээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон .... орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халхгол сумын Засаг дарга Х.Хүрэл-Эрдэнэ, санхүүгийн албаны дарга Б.Отгонтуяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Г.ГАНБИЛЭГ



011041341



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 03/113 ДА-2024/10/НА-СТА-ТТЗ  
11171130

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэх 165.6 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д "Хөрөнгө оруулалтын төсөвт...хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 44.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халхгол сумын Засаг дарга Х.Хүрэл-Эрдэнэ, санхүүгийн албаны дарга Б.Отгонтуяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АУДИТОР

Г.ГАНБИЛЭГ



011041342

